



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн  
газрын 2022 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах  
ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө”-г хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг шинэчлэн батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг холбогдох нэгжүүдэд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/-т, Санхүү, эдийн засгийн хэлтэс /Л.Лувсан/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/05 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ

1522010220



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН 2022 ОНЫ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ЕРӨНХИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Тендер шалгаруулалтын код	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төрөл (бараа, ажил, зөвлөх үйлчилгээ, зөвлөхөөс бусад үйлчилгээ)	Төсөвт өртөг (мян.төг)	Тухайн онд санхүүжих дүн (мян.төг)	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга	Тендер зарлах огноо	Тайлбар, тодруулга
<b>УРСГАЛ ТӨСӨВ</b>								
1		Газрын мониторингийн үндэсний сүлжээний тариалангийн газрын мониторингийн 100 цэгт спектрометрийн хэмжилт, газрын чанарын улсын хянан баталгааны ажил хийх	Зөвлөх үйлчилгээ	13.0	13.0	ШХА	2022.03.01	
2		Геодезийн сүлжээний эхлэл цэгийг өндрийн 1-р ангийн сүлжээтэй холбох хэмжилт хийх	Ажил	50.0	50.0	ХА	2022.02.15	
3		Байр зүйн болон кадастрын зургийн алдааг хянах, засварлах /Говьсүмбэр аймаг, Шивээговь сум/	Зөвлөх үйлчилгээ	7.0	7.0	ШХА	2022.03.01	
4		Байр зүйн зургийн алдааг засах, ITRF2008 эринд шилжүүлэх /Баянхонгор аймаг, Баянхонгор сум/	Зөвлөх үйлчилгээ	16.0	16.0	ШХА	2022.03.01	
5		Хэнтий аймгийн Хэрлэн сумын төвийн барилгажсан хэсгийн 3D зураглалд зориулсан агаарын зураг авах, боловсруулах	Зөвлөх үйлчилгээ	19.5	19.5	ШХА	2022.03.01	
6		MONPOS онлайн боловсруулалтын системийн алдааг засварлах, хөгжүүлэх	Зөвлөх үйлчилгээ	10.0	10.0	ШХА	2022.02.15	
7		Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системийн хөгжүүлэлт	Зөвлөх үйлчилгээ	50.0	50.0	НТШ	2022.02.15	
8		Газрын татвар, төлбөрийн системийн хөгжүүлэлт	Зөвлөх үйлчилгээ	20.0	20.0	ШХА	2022.01.20	
9		Газрын биржийн цахим системийн хөгжүүлэлт	Зөвлөх үйлчилгээ	40.0	40.0	НТШ	2022.02.15	
10		Хянан баталгаа, мониторингийн системийн хөгжүүлэлт	Зөвлөх үйлчилгээ	10.0	10.0	ШХА	2022.01.20	
11		Газрын цахим систем, Гар утасны аппликэйшин /www.egazar.gov.mn/-ын хөгжүүлэлт	Зөвлөх үйлчилгээ	20.0	20.0	ШХА	-	
12		Antivirus license-ийн сунгалт /худалдан авалт/	Бараа	24.0	24.0	ХА	2022.06.15	
13		Түүхэн зураг зориулалтын дагуу хадгалах шүүгээ худалдан авах	Бараа	9.0	9.0	ШХА	-	
14		Агаар чийгшүүлэгч худалдан авах	Бараа	10.0	10.0	ШХА	-	
<b>НИЙТ ДҮН</b>				<b>298.5</b>	<b>298.5</b>			